



МОНГОЛ УЛС  
ТӨВ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН  
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 09 сарын 19 өдөр

Дугаар А/07

Зуунмод

Төрийн үйлчилгээний албан  
хаагчдын албан тушаалын тодорхойлолт  
боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор баталсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын 3.2 дахь хэсэг, Төв аймгийн Засаг даргын 2022 оны А/01 дүгээр захирамж “Орон нутгийн өмчийн газрын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай”-ийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төв аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан төрийн үйлчилгээний албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж, батлуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

А.Зоригоо

(Худалдан авах ажиллагааны албаны дарга)

Гишүүд:

Б.Баярсайхан

(Өмчийн бодлого, зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн)

М.Болормаа

(Дотоод ажил, хүний нөөц, архив албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтан)

2. Албан тушаалын тодорхойлолтын төслийг 05 дугаар сарын 01-ний дотор боловсруулан, батлуулж, хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо цахим системд оруулахыг ажлын хэсгийн ахлагч (А.Зоригоо), гишүүн (М.Болормаа) нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Д.БАТЖАРГАЛ

3370236 4116128393